



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/93

Улаанбаатар хот

**Дуудлагын худалдааг зохион байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 38-44 дүгээр зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчийг хувьчлах журам”, “Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын дүрэм”-ийн 2 дугаар бүлгийн 2.5.3 дахь заалт, 3 дугаар бүлгийн 3.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн өмчөөс хувьчлах хуулийн этгээд, эд хөрөнгийн 2021 оны нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. Нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийг тухай бүр танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (Б.Болор-Эрдэнэ)-т даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2020 оны А/63 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



М. БАЯРАА

Тушаал-2021

115050000277